



ҮНДЭСТЭН ДАМНАСАН ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХЭД ПРОКУРОРЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ: ХУУЛЬ БУС ХӨРӨНГИЙГ МӨШГӨХ, БУЦААН АВАХ БА ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦОО

ЗОРИЛГО

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд прокурорын гүйцэтгэх үүрэг, хууль бусаар олсон хөрөнгийг мөшгөх, царцаах, хураах, буцаан авах болон холбогдох хариуцлагын тогтолцооны эрх зүйн зохицуулалт, практик хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлох, тэдгээрийг шийдвэрлэх үр нөлөөтэй арга замыг тодорхойлоход оршино.

ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

Улсын ерөнхий прокурорын газар

ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

Монголын Хуульчдын холбоо

ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар

ИЛТГЭЛИЙН ЧИГЛЭЛ

1. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн нөхцөл байдал, санхүүгийн урсгал, мөнгө угаах арга хэлбэр, чиг хандлагын өөрчлөлт, тэдгээрээс үүдэн хууль бус хөрөнгийг мөшгөх, нотлох ажиллагаанд тулгарч буй сорилт, бэрхшээл;
2. Хууль бус хөрөнгийг мөшгөх, царцаах, хураах, буцаан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн үр нөлөө, нотлох баримтын стандарт;
3. Хууль бус хөрөнгийг буцаан авах ажиллагаа, түүний удирдлага (asset management), гадаад улсын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх асуудал, олон улсын хамтын ажиллагааны бодит туршлага;
4. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх албан, албан бус хамтын ажиллагааны механизм, улс хоорондын мэдээлэл солилцоо, байгууллага хоорондын уялдаа холбоо, түүний үр нөлөө;
5. Хөрөнгийн урсгалыг мөшгөх, нотлох ажиллагааг удирдан чиглүүлэх, олон улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлэхэд прокурорын гүйцэтгэх үүрэг, тулгамдаж буй асуудал;
6. Хууль бус хөрөнгийг хураах, буцаан авах ажиллагаанд иргэний болон эрүүгийн эрх зүйн механизмыг хослуулан хэрэглэх боломж, хариуцлагын тогтолцооны уялдаа холбоо, түүний үр нөлөө;
7. Хууль бус хөрөнгийг мөшгөх, нотлох ажиллагаанд технологийн дэвшлийг ашиглах боломж, эрх зүйн зохицуулалт, практик хэрэгжилт, түүнтэй холбоотой эрсдэл, сорилтууд;
8. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийг шүүхэд яллах ажиллагааны онцлог, тулгамдсан асуудал.

ОРОЛЦОГЧДЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Шүүх, хууль сахиулах болон төрийн бусад байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, их сургуулийн төлөөлөл, хуульч, эрдэмтэн, судлаачид илтгэл ирүүлж оролцоно. Илтгэгч дангаар эсхүл бусадтай хамтран илтгэл бэлтгэж болно.

ИЛТГЭЛ ИРҮҮЛЭХ ХУГАЦАА

Илтгэлийг 2026 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн дотор илтгэгчийн 4x6 хэмжээтэй зураг (jpg)-ийн хамт gpo_tri@prosecutor.mn хаягаар ирүүлнэ.

ИЛТГЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Илтгэл нь үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд прокурорын гүйцэтгэх үүрэг, хууль бус хөрөнгийг мөшгөх, царцаах, хураах, буцаан авах болон хариуцлагын тогтолцооны асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судлан дүн шинжилгээ хийсэн, нотолгоонд суурилсан, академик бүтээл байна.

ХОЛБОО БАРИХ, МЭДЭЭЛЭЛ АВАХ УТАС, ХАЯГ:



ҮНДЭСТЭН ДАМНАСАН ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХЭД ПРОКУРОРЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ: ХУУЛЬ БУС ХӨРӨНГИЙГ МӨШГӨХ, БУЦААН АВАХ БА ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦОО

Агуулгын шаардлага

- Илтгэлийн агуулгыг хурлын сэдэвтэй уялдуулан тодорхой хүрээнд асуудал дэвшүүлсэн байх;
- Шинэлэг хандлага, дүгнэлт, арга зүйн шийдлийг тусгасан байх;
- Онолын болон практик ач холбогдол бүхий дүгнэлт, санал дэвшүүлсэн байх;
- Олон улсын болон үндэсний туршлага, харьцуулсан шинжилгээнд тулгуурласан байх;
- Дүгнэлт нь нотолгоо болон эх сурвалжид үндэслэсэн байх.

Бүтцийн шаардлага

Илтгэл нь дараах үндсэн бүтэцтэй байна.

- Гарчиг
- Илтгэгчийн эрдмийн зэрэг, цол, албан тушаал
- Хураангуй (монгол эсхүл англи хэлээр)
- Түлхүүр үг
- Оршил
- Үндсэн хэсэг (судалгааны арга зүй, дүн шинжилгээ)
- Дүгнэлт, санал
- Ашигласан материал

Найруулга, хэл зүй

Илтгэлийн найруулга, хэл зүй нь дараах шаардлагыг хангасан байна.

- Тодорхой байдал: агуулга нь ойлгомжтой, илэрхийлэл нь товч, хоёрдмол утга агуулаагүй байна;
- Логик уялдаатай байдал: найруулга, хэл зүйн хувьд алдаагүй, логик уялдаа хангагдсан байна;
- Нэр томъёоны хэрэглээ: хууль зүйн болон мэргэжлийн нэр томъёог зөв, оновчтой хэрэглэсэн байна.

Эх сурвалж, ишлэл

Илтгэлд ашигласан эх сурвалж, ишлэл нь дараах шаардлагад нийцсэн байна.

- Ашигласан эх сурвалжийг нэг стандарт (APA, OSCOLA зэрэг)-ын дагуу жигд ишилсэн байх;
- Олон улсын болон үндэсний эх сурвалж, тухайлбал хууль тогтоомж, шүүхийн практик, олон улсын байгууллагын баримт бичиг, судалгааны бүтээлийг холбогдох шаардлагын дагуу ашигласан байх;
- Бүтээл нь хуулбарлалтаас ангид байх.

Ёс зүйн шаардлага

- Судалгааны ёс зүйг баримталсан байх;
- Зохиогчийн эрхийг хүндэтгэсэн байх.

Хэлбэр, формат

Илтгэлд дараах форматын шаардлага тавигдана.

- Монгол эсхүл англи хэл дээр бичигдсэн байх;
- А4 хэмжээ, 6-8 нүүр;
- Times New Roman, 12 pt;
- Мөр хоорондын зай 1.15;
- MS Word формат.

ШАЛГАРУУЛЖ ХЭЛЭЛЦҮҮЛЭХ

Олон улсын эрдэм шинжилгээний хурлаар хэлэлцүүлэх илтгэлийг шинжлэх ухааны болон бодлогын ач холбогдол, шинэлэг байдал, арга зүйд үндэслэн шалгаруулна. Эрдэм шинжилгээ, судалгааны нийтлэг шаардлага хангасан илтгэлүүдийг эмхэтгэн хэвлүүлж, олон нийтэд түгээнэ.